



УЛААНБААТАР  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 6/259

Улаанбаатар хот

Д.Алтанчимэгийг ажлаас чөлөөлж,  
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.3, Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, Компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Сонгинохайрхан хэрэглэгчдэд үйлчлэх төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан байцаагч инженер Дамбын Алтанчимэг /122241/-ийг 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.


2. Д.Алтанчимэгт эрчим хүчний салбарт 34 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000 төгрөг/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 45,696,000 /дөчин таван сая, зургаан зуун ерөн зургаан мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

3. Д.Алтанчимэгийн ажлыг хүлээлцүүлж, ээлжийн амралтын олговрыг 5,5 хоногоор тооцож, холбогдох тооцоог хийж дуусгахыг Сонгинохайрхан хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга /Ц.Мөнхтогоо/-д үүрэг болгосугай.

4. Д.Алтанчимэгт нэг удаагийн тэтгэмжийн 45,696,000 /дөчин таван сая, зургаан зуун ерөн зургаан мянга/ төгрөг олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН

e:\2021 он\ashigfalt-2\эхнх\тэтгэвэрт гаргах.docx

3170601875